

## **БНМАУ, ХБНГУ-ын харилцаа 1990 он – дүгнэлт, эрэгцүүлэл**

Ц.Лхам (М.А)

ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

Монгол Улс, ХБНГУ-ын хооронд 1974 онд дипломат харилцаа тогтсоноос хойш 1990 онд л хоёр орны харилцаа идэвхжиж эхэлсэн билээ. Тэгвэл 1990 оны хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны байдлыг нэгтгэн дүгнэж, өнөөдрийн өндөрлөгөөс эргэцүүлэн нэг харахад эрхгүй нэг дутагдал байгааг олж харав. Энэ нь тухайн үед тулгамдаж байсан тэрхүү асуудлыг бид цагт нь шийдэж чадаагүйгээр үл барам өнөөг хүртэл цалгардуулснаас эдүгээ Монгол-Германы эдийн засгийн харилцаа нэг талаар байнга хоцрогдсоор ирсэн юм болов уу гэсэн дүгнэлтийг хийж байна.

### **Соёлын хамтын ажиллагаа**

1990 онд хоёр орны хамтын ажиллагаа соёлын салбарт Засгийн газрын хоорондын соёлын солилцооны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн бөгөөд уг хөтөлбөр нь ХБНГУ, БНМАУ-ын Засгийн газар хооронд соёлын талаар хамтран ажиллах 1986 оны VI сарын 12-ны хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор 1988 онд байгуулагдсан, 3 жилийн хугацаагаар хэрэгжих хөтөлбөр байв. Түүнд соёл урлаг, шинжлэх ухаан, боловсрол, мэргэжил дээшлүүлэх сургалт, утга зохиол, радио телевизийн салбарыг хамарсан нийт 16 арга хэмжээ тусгагдсаны талаас илүү нь дан ганц Монголын талд ашигтай, Монголын талд хандсан арга хэмжээ байх агаад үүний 70% нь сургалтанд хамруулж, мэргэжил дээшлүүлэхэд чиглэгдсэн бол үлдэх 30% Германд Монголыг сурталчилахад чиглэгдсэн байжээ. Харин зөвхөн Германы талд ашигтай, түүнд хандсан арга хэмжээ ердөө хоёрхон байгаагаас үзэхэд энэхүү хөтөлбөрийг байгуулж, БНМАУ-тай соёлын салбарт хамтран ажиллах явдлыг дэмжихдээ баримталсан Германы талын бодлого нэгдүгээрт, мэргэжил дээшлүүлэх салбарт, хоёрдугаарт, Монголыг Германд сурталчлах гэсэн хэлбэрээр явагдсан нь харагдаж байна.

### **Хөгжлийн хамтын ажиллагаа**

Хөгжлийн хамтын ажиллагаа нь санхүүгийн хамтын ажиллагаа, техникийн хамтын ажиллагаа гэж хуваагдах бөгөөд санхүүгийн хамтын ажиллагаа нь дотроо хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж гэж ангилагдана.

**Санхүүгийн хамтын ажиллагааны хувьд:** Өрнөд Европын Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (OECD) БНМАУ-ыг хөгжиж буй орон гэж албан ёсоор хүлээн зөвшөөрсөн учир ХБНГУ-ын Засгийн газар Монголд хөгжлийн зориулалттай тусламж олгох албан ёсны урьдчилсан нөхцөл бүрдлээ гэж Германы тал 1990 онд үзсэн<sup>1</sup> бөгөөд гэвч 1990 оны хувьд ХБНГУ нь Ангол, Намиби зэрэг Африкийн орнуудад хөгжлийн зориулалттай нэлээд тусламж үзүүлэхээр тохиролцсон учир Монголд тусламж үзүүлэх санхүүгийн боломжгүй байна гэсэн байр суурьтай байв.<sup>2</sup>

1990 оны XI сарын 14-нд МУ-ын Ерөнхий сайд Д.Бямбасүрэнгээс Холбооны Канцлер Хельмут Кольт захидал илгээж, нэгдүгээрт, буурай хөгжилтэй оронд олгодог хөнгөлөлттэй нөхцөлөөр 1,5 млрд ДМ-ийн зээлийг БНМАУ-д олгох, хоёрдугаарт, хуучин БНАГУ-БНМАУ-ын хооронд шилжих рублиэр үүссэн зээлийн өр, хүүгийн төлбөр болон худалдааны балансын төлбөрийг хүчингүй болгож өгөхийг хүссэн байна.<sup>3</sup> 1991 оны I сарын 11-нд Холбооны Канцлер Х.Колиос Ерөнхий сайд Д.Бямбасүрэнд илгээсэн хариу захидалд "... Таны захидалд дурдсан зээлийн хэмжээнд юм уу түүнд ойртож очих хэмжээний зээлийг олгох асуудал хэрэгжиж чадахгүй байх гэж бодож байна. ... БНМАУ-ын худалдааны балансын алдагдлыг шилжих рублиэр тогтоон улмаар нийт өрийн асуудлыг хоёр орны эдийн засгийн эрх ашигт нийцүүлэн зохицуулахад Холбооны Засгийн газар бэлэн байна."<sup>4</sup> гэсэн хариуг өгсөн байна. Ер нь практик дээр ХБНГУ буурай хөгжилтэй орны өрийг хүчингүй болгодог туршлага байдаг хэдий ч тухайн үед Монгол Улс буурай хөгжилтэй орны жагсаалтанд байдаггүй байв. Харин ХБНГУ нь 1 хүнд ногдох Үндэсний орлогыг харгалзан үзэж Вьетнам зэрэг оронд 0,74%-ийн хүүтэй, 40 жилийн хугацаатай, эхний 10 жилд хүүг төлөхгүй байх нөхцөлөөр хөнгөлөлттэй зээл олгодог байжээ.

<sup>1</sup> БНМАУ-ын Гадаад Харилцааны Архив, Ф№70, Х/Н№38, БНМАУ, ХБНГУ-ын улс төрийн харилцаа (1990-1/14-нөөс 1991-1/11)

<sup>2</sup> мөн тэнд

<sup>3</sup> БНМАУ-ын Гадаад Харилцааны Архив, Ф№70, Х/Н№38, БНМАУ, ХБНГУ-ын улс төрийн харилцаа (1990-1/14-нөөс 1991-1/11)

<sup>4</sup> мөн тэнд

**Техникийн хамтын ажиллагааны хувьд:** 1990 оны намар хоёр Германы нэгдсэн төлөөлөгчид БНМАУ-д айлчилж, хуучин БНАГУ-ын үед хэрэгжүүлж байсан төслүүдтэй газар дээр нь нэг бүрчлэн ирж танилцсаны эцэст ХБНГУ-ын тал:

- Эдгээр төслүүдээс Бороогийн хайгуулын ажил, эктопаразиттай тэмцэх гэсэн зөвхөн хоёрхон төслийг цаашид зайлшгүй үргэжлүүлэх нь ач холбогдолтой гэж үзсэн тул цаашид үргэжлүүлэн санхүүжүүлнэ.

- Харин техник, эдийн засгийн үр дүн муутай тусламжийн жишээ болсон Борнуурын САА, Мах комбинат зэргийн аргагүй байдлыг үндэслэн эцсийн удаа санхүүжүүлэх нь зүйтэй гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

### **Улс төр, эдийн засгийн хамтын ажиллагаа**

1990 онд манай улс ХБНГУ-ын Бонн хотод Элчин Сайдын Яамаа нээсний зэрэгцээ Берлин дэх хуучин ЭСЯ-ныхаа байрыг салбарын статустайгаар үлдээжээ. Учир нь нэгдүгээрт, БНАГУ манай эдийн засгийн харилцааны чухал түнш байсны хувьд тэнд манай гол түнш байгууллагууд байрлахын хамт Монголын олон зуун иргэд сурч байгааг харгалзан үзсэн, хоёрдугаарт, тодорхой хугацааны дараа Берлин нэгдсэн Германы нийслэл болох байсан тул ЭСЯ-ны одоогийн байр сууцыг хадгалж үлдэх нь зүйтэй гэж үзсэн тул тухайн үед эл шийдвэрийг гаргажээ.<sup>5</sup>

Мөн Германы тал 1990 онд БНМАУ дахь хуучин БНАГУ-ын Элчин Сайдын Яамны барилга зэрэг материаллаг баазыг ашиглан БНМАУ-д байнга суух элчин сайдын яамаа нээсэн билээ. Энэ нь БНМАУ, хуучин БНАГУ хоорондын эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн болон бусад харилцааны түвшинг бууруулахгүй байх чиг бодлогыг ХБНГУ-ын Засгийн газар баримталж байсны нэг илрэл байв.<sup>6</sup>

Энэ үед БНМАУ-аас ХБНГУ-д хавсран суугаа элчин сайд Х.Сэрээтэр болон 1990 оны намраас МУ-аас ХБНГУ-д байнга суух элчин сайдаар томилогдсон А.Цолмон нар ХБНГУ-ын Холбооны Гадаад хэргийн яам, Холбооны Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам, Холбооны Эдийн засгийн яам болон зарим хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагуудтай хоёр орны харилцааны талаар санал солилцож эхэлсэн. Эдгээр уулзалтын ярианы тэмдэглэлээс үзэхэд тухайн үед хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг эрчимтэй эхлүүлэхэд нэн шаардлагатай, авбал зохих тулгамдсан арга хэмжээнд:

<sup>5</sup> мөн тэнд

<sup>6</sup> мөн тэнд

- хоёр орны хооронд эдийн засгийн хамтын ажиллагааны зарчмын хэлэлцээр байгуулах - Учир нь ХБНГУ-ын Засгийн газар, худалдаа, эдийн засгийн төрийн байгууллагууд БНМАУ-ыг хөгжиж буй орон гэж албан ёсоор хүлээн зөвшөөрөөд хөгжлийн зориулалттай зээл, тусламж олгож болно гэж үзэж байсан хэдий ч хоёр орны хооронд эдийн засгийн хамтын ажиллагааны гэрээ байгуулаагүй тул ХБНГУ-ын үйлдвэр, пүүсүүдээс БНМАУ-д хамтарсан үйлдвэр барих, түүнд шаардагдах зардлыг санхүүжүүлэх хууль эрхийн үндэслэл алга байна гэж үзэж байлаа.

- Хоёр орны хооронд хөрөнгө оруулалтыг харилцан хамгаалах, хөхүүлэн дэмжих хэлэлцээр байгуулах – Учир нь ХБНГУ-аас хөгжиж буй орнуудад хамтарсан жижиг, дунд үйлдвэр барих хөгжлийн зориулалттай зээл тусламжийг санхүүжүүлэхэд гол төлөв олон нийтийн янз бүрийн нийгэмлэг, хувийн үйлдвэр пүүсүүд оролцдог бөгөөд тэдэнд гадаад оронд оруулсан хөрөнгөө найдвартай болгосон хууль эрхийн баталгаа, хөрөнгө оруулалтыг хамгаалах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр заавал шаардлагатай байв.

- ЕЭЗХН-тэй худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулах – Учир нь ХБНГУ ЕЭЗХН-ийн гишүүн орны хувьд түүний эдийн засгийн зарим салбар үүний дотор худалдааг нэгдсэн бодлогоор ЕЭЗХН-ийн түвшинд зохицуулах болсон билээ.

- БНМАУ-ын эдийн засгийн бүтэц, зохион байгуулалтаас эхлээд энэ салбарт хийгдэж буй өөрчлөлт, шинэчлэлтийн хүрээ хэмжээ, гадаад орнуудтай ялангуяа хөрөнгөтөн оронтой эдийн засгийн салбарт хамтран ажиллах бодлого, концепц зэргийг ХБНГУ-ын талд мэдээлэх, таниулах байнгын механизмыг бий болгох – Эдгээр мэдээлэлгүйгээр ХБНГУ-ын төрийн ба төрийн бус, хувийн хэвшлийн аль ч байгууллагын хувьд манай оронтой эдийн засгийн салбарт хамтран ажиллах асуудлаар ямар нэг алхам хийж, шийдвэр гаргах явдлыг дөнгөлж байлаа.

Өнөөгийн өндөрлөгөөс эргэн нэг харахад дээр дурдсан 4 тунгамдсан асуудлын нэгээс бусдыг нь бүрэн биелүүлжээ. Тухайлбал:

- 1995 онд харилцааны ерөнхий хүрээ, үндсэн зарчмыг тодорхойлсон “МУ, ХБНГУ-ын харилцааны үндсийн тухай хамтарсан тунхаглал”-ыг байгуулсан.

- “БНМАУ, ХБНГУ-ын хоорондын хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай гэрээ”-г 1991 оны 6 дугаар сарын 26-нд, “Орлогын болон хөрөнгийн татварыг давхардуулан

ноогдуулахгүй байх тухай хэлэлцээр"-ийг 1994 онд тус тус байгуулсан байна.

- Манай улс Европын Холбоотой 1992 оны 6 дугаар сарын 16-нд Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зуржээ.

Харин сүүлчийн асуудал буюу Монгол Улс улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгмийн байдлын талаарх мэдээллийг германчуудад хүргэх байнгын механизм илтэд дутагдсаар л байна. 1995 оноос хойш хоёр орны харилцаа эрс өргөжиж, шил шилээ даран хийгдэж буй албан ёсны харилцан айлчлалууд, жилдээ ганц нэг удаа оролцох олон улсын үзэсгэлэн, яармаг худалдаа, аль нэг тэмдэглэлт ойгоор хэдэн жилдээ нэг тохиох Монголын соёлын өдрүүд, өдөрлөг, түүх, угсаатны зүйн үзэсгэлэн зэргийн ачаар өнөөгийн Монголын талаар бараг ойлголтгүй шахам байсан германчуудад бага зэргийн ойлголт, төсөөлөл өгснөөс бус хангалттай цогц мэдээллийг (өөрөөр хэлбэл шинжлэх ухааны түвшинд хийгдсэн судалгаа гэсэн үг) хараахан өгч чадаагүй бололтой. Хэрэв тийм биш гэвэл манай уул уурхайн салбарт томоохон төслүүд дээр олон олноороо биш гэтэл ганц нэг ч болов Германы хөрөнгө оруулалт орж ирмээр юм.

Иймд герман судлаачдын сонирхлыг татах дараагийн сэдэв нь "ХБНГУ-д өнөөгийн Монголын тухай судалгаа, мэдээллийг түгээх байнгын механизмыг хэрхэн бий болгох вэ?" гэсэн гарчигтай байх болов уу. Үүнд монгол судлаачдынхаа судалгааны сайн бүтээлүүд болон олон улсын янз бүрийн байгууллагуудын шугамаар хийгдсэн Монголын тухай тодорхой судалгаануудыг ашиглах замаар энэ ажлыг зохион байгуулахад болохгүй гэх газаргүй бус уу.